

## **Сүм хийд байгуулах зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг**

Сүм хийд байгуулах, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авахыг хүссэн иргэд аймгийн ИТХ-д дараах бичиг баримтыг холбогдох хууль тогтоомжинд нийцүүлэн бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:

1. Сүм хийд байгуулах шаардлага, үйл ажиллагааны онцлогийг тусгасан өргөдөл.

2. Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 7 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь заалтуудын шаардлагыг хангаж батлагдсан дүрэм. /Дүрэмд мөн сүм хийдийн зорилго, шүтэж итгэдэг, биширдэг номлолын үндсэн үзэл санаа, тухайн сүм хийдээс шүтэн бишрэгчид, сүсэгтний дунд зохион байгуулах ажлын, гол агууллага чиглэл зэргийг тусгасан байна/

3. Тухайн сүм хийдийг байгуулахаар санал нэгдсэн санаачлагч иргэдийн хурлын шийдвэр, дэлгэрэнгүй протокол.

4. Сүм хийд байгуулахаар санал нэгдсэн иргэдийн бүртгэл, овог нэр нас, регистрийн дугаар, зөвшөөрснийг гэрчлэх гарын үсэг.

5. Удирдах байгууллагын гишүүд, ахлагчдын дэлгэрэнгүй анкет.

6. Сумын ИТХ, Засаг даргын санал.

7. Сүм хийдийн үйл ажиллагаа явуулах барилга байгууламж, байр танхимтайг нотлох баримт бичиг, газрын зөвшөөрөл.

8. Хэрэв нийслэл болон өөр нутагт үйл ажиллагаа явуулж буй сум хийдийн салбар бол тухайн төв байгууллагын зөвшөөрлийн хуулбар, хүсэлт, тодорхойлолт.

9. Тухайн сүм хийдэд номлол сургаалийг айлдагч гадаадын зөвлөх багшийн нэр, хаяг, Гадаадын иргэн харьяатын асуудал эрхлэх болон Цагдаагийн байгууллагад бүртгүүлсэн тухай тодорхойлолт.

10. Тухайн багийн нутагт сүм, хийд байгуулахыг дэмжсэн Багийн иргэдийн Нийтийн Хурлын тогтоол, тэмдэглэл

ооо